

БАТЛАВ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Б.ГАНХУЯГ

Огноо:  
2019 оны сарын өдөр



**“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК**

Тендер шалгаруулалт  
гэрээний нэр:

**АЖИЛЧДЫН КАСК НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ ХАРЬЦУУЛАЛТЫН ТЕНДЕР**

Тендер  
шалгаруулалт гэрээний  
дугаар:

**ЭТТ/201901343**

ТАНИЛЦСАН:  
БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР  
ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ  
ОГНОО.....

Б.БАТСАЙХАН

ХЯНАСАН:  
ХУДАЛДАН АВАЛТ, ХАНГАН  
НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
ОГНОО.....

М.БАТ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:  
ХУДАЛДАН АВАЛТ, ХАНГАН  
НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХЭЛТСИЙН МЕНЕЖЕР  
ОГНОО.....

Б.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАСАН:  
ХУДАЛДАН АВАЛТЫН  
АЛБАНЫ ДАРГА  
ОГНОО.....

Ж.АМГАЛАНБАЯР

УЛААНБААТАР ХОТ  
2019 он



**“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК**

Тендер шалгаруулалт  
гэрээний нэр:

**АЖИЛЧДЫН КАСК НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ ХАРЬЦУУЛАЛТЫН ТЕНДЕР**

Тендер шалгаруулалт  
гэрээний дугаар:

**ЭТТ/201901343**

**БОЛОВСРУУЛСАН: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН 2019 ОНЫ 03 ДУГААР САРЫН 19-НЫ  
ӨДРИЙН А/126 ДУГААРТАЙ ТУШААЛААР БАТЛАГДСАН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО**

**ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА:**

**Ц.МӨНХТУЯА**

**ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ГИШҮҮД:**

**Б.МЯГМАРДАВАА**

**Б.ТУНГАЛАГ**

**С.АЗЖАРГАЛ**

**П.ГАНТУЯА**

**С.ЦЭРЭНПҮРЭВ**

**ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА**

**Ж.ДАВААЖАРГАЛ**

**УЛААНБААТАР ХОТ  
2019 он**

**“Эрдэнэс-Тавантолгой ХК”**

Огноо: .....

**АЖИЛЧДЫН КАСК НИЙЛҮҮЛЭХ  
ҮНИЙН САНАЛ  
АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр: Ажилчдын каск нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох**

**Харьцуулалт/  
гэрээний дугаар: ЭТТ/201901343**

### **Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

**“Эрдэнэс-Тавантолгой” ХК** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Ажилчдын каск”** нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭТТ/201901343 дугаартай харьцуулалтын тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 11 цаг 00 минутад “Эрдэнэс Тавантолгой” ХК, Жигжиджав-8, Финанс төв, 5 давхрын хурлын өрөөнд нээнэ.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8,  
Финанс төв 5 давхар, 503 тоот, Улаанбаатар-15160,  
Худалдан авалт, ханган нийлүүлэлтийн хэлтэс  
Утас: 70118484-562**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тогтмол үнэ
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
  - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
  - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
  - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 1 жилийн буюу 2018 оны баталгаажсан санхүүгийн тайлангийн хуулбар хувь</li> <li>2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>3. Сүүлийн 2 жилийн 2017, 2018 оны аль нэг жилд ижил төстэй 1-ээс доошгүй бараа нийлүүлсэн гэрээг нотариатаар баталгаажуулан гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлэх.</li> <li>4. Татварын газрын цахим тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар ирүүлэх/</li> <li>5. НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар</li> <li>6. Санал болгож буй барааны танилцуулга ирүүлэх/Тендерийн баримт бичигт заагдсан техникийн үзүүлэлттэй харьцуулсан үзүүлэлт, зураг</li> <li>7. ШШГЕГ-ын шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт ирүүлэх /тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр хугацаатай байна/</li> <li>8. Барааны гарал үүслийн гэрчилгээ, нотлох баримтыг ирүүлэх</li> <li>9. Чанарын гэрчилгээ хуулбар орчуулгын хамт</li> <li>10. Тендерт шалгарсан тохиолдолд санал болгосон бараа техникийн тодорхойлолтын дагуу бараа материал нийлүүлэх гэсэн албан бичиг ирүүлнэ үү.</li> <li>11. Техникийн тодорхойлолтод заагдсан каскны загвар дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө ирүүлнэ.</li> </ol> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. /ҮГҮЙ/</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:  Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот-15160, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8, Финанс төв</b>  <b>Утас: 70118585 (562), факс: 70118464</b>  Давхар болон ерөөний дугаар: <b>5 давхар 503 тоот</b>  Огноо: <b>2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр</b>  Цаг: <b>10 цаг 30 минут</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот-15160, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8, Финанс төв</b>  Давхар болон ерөөний дугаар: <b>5 давхар 503 тоот</b>  Огноо: <b>2019 оны 04 дүгээр сарын 16 -ны өдөр</b>  Цаг: <b>11 цаг 00 минут</b></p>
ТӨӨЗ 6.2	<p><b>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</b></p>

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Барааны тодорхойлолт:

#### ЗОРИУЛАЛТ:

#### ТОЛГОЙ ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ (ДУУЛГА, КАСК)

#### ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:

Толгой хамгаалах дуулга нь MNS 5621: 2006 Монгол улсын стандарт болон ANSI/ISEA Z89.1 2009 стандартын шаардлагыг хангасан байна.

1.1	Өнгө:	Шар, Цагаан, Улаан
1.2	Материал:	Полиэтилен-PE, поликорбанат-PC материалаар хийгдсэн байна. Олон улсын стандартын шаардлагад нийцсэн материалаар хийгдсэн байна.
1.3	Чанар:	Бүтээгдэхүүнд үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна. Хэрэглээний болон технологийн тодорхойлолтонд хэрхэн нийцсэн, хүний биед таарч байгаа байдлаар тодорхойлогдоно. Олон улсын чанарын стандарт хангасан MSA брэндийн хамгаалах хэрэгсэлтэй дүйцэхүйц чанартай хамгаалалтын хэрэгсэл байна. ANSI/ISEA Z89.1 2009 эсхүл AS/ NZS 1801 стандартын шаардлага хангасан гэсэн тэмдэглэгээ, бичиг нь каскны дотор талын шошго болон каскан дээр бичсэн байна. Ихэвчлэн барилгын зориулалтаар ашигладаг, хөнгөн жинтэй дуулгыг чанарын шаардлага хангахгүй гэж үзнэ.
1.4	Ангилал, Бүтэц:	Толгой хамгаалах хэрэгсэл нь дараах бүтэцтэй байна: <ul style="list-style-type: none"> <li>• Толгой хамгаалах дуулгын их бие,</li> <li>• Дуулга тогтоох эрүүвчтэй (резинэн эрүүвч) байна.</li> <li>• Бүслэвчийг толгойд тохируулах цагираг,</li> <li>• Толгойн оройноос хөндийрүүлэх татуурга,</li> <li>• Толгойн хөлс шингээгч жиргэвч.</li> </ul> Хамгаалалтын малгайн дотор: <ul style="list-style-type: none"> <li>• Хамгаалалтын малгайны тохируулагч нь ихэсгэж, багасгадаг тохируулгатай байна.</li> <li>• Тохируулга нь эргүүлдэг байна.</li> <li>• MSA брэндийн дотортой дүйцэхүйц байна.</li> <li>• Чанарын хувьд бат бөх сайн.</li> </ul>
1.5	Үзүүлэлт:	Дуулга нь механик үйлчлэл, 400-1000 В цахилгаан хүчдэл, -50°C-аас +150°C температурын нөлөөнөөс толгойг хамгаалах чадвартай байна. Хамгаалалтын дуулга толгойд ирэх 50 Дж / Джоуль/ цохилтын энергитэй, 5 кН / Килоньютон/ -с их хүчийг толгой руу дамжуулахгүй ба 30 Дж энергитэйгээр дээрээс унасан зүйл толгойд хүрэхгүй байх ёстой. Өнгө үзэмж сайтай, 300 гр-аас илүүгүй жинтэй байна. Толгойнд тогтоогч сүлжмэл тууз нь 4 цэгт бэхлэгдсэн байна. Хамгаалалтын дуулга нь унахгүйгээр толгойн дээр тогтож байх зориулалтын бэхлэгээний системтэй байна. Хамгаалалтын дуулганы эрүүвч туузын өргөн 15 мм-ээс багагүй байна. Үйлдвэрлэсэн он сар өдөр нь бичээстэй байх ба тэр хугацаа нь 2017 оноос хойш байна. Толгой хамгаалах хэрэгслийн ашиглалтын бичиг баримтад ашиглалтын хэмийн зааглал, цахилгаанаас хамгаалах шинж чанар, ашиглалтын нөхцөл, зэргийг үйлдвэрлэгчээс зааж өгсөн байна. MSA брэндийн ANSI/ISEA Z89.1 2009 стандартын Type I Class C загварын V-Gard нэр бүхий хамгаалалтын малгайтай дүйцэхүйц чанартай малгай байна. Орой дээрээ нүхгүй, хажуу болон ар талаар тойрсон хүрээний ирмэг нь дээш эргэсэн загвартай байна (зураг дээр үзүүлсэн).
1.6	Хэмжээ:	52-64 размер хэмжээнд тохируулах боломжтой байна.



### 2. Стандарт: Захиалагч холбогдох стандартыг заана. Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн гэрчилгээ.



3. **Баглаа, боодол:** Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.
4. **Бараа хүргэх газар:** Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хотын агуулах
5. **Бараа нийлүүлэх хуваарь: 15 хоног**

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Каск /цагаан/		250			7 хоног	14 хоног	
Каск /шар/		200					
Каск /улаан/		50					
Каск /цэнхэр/		100					

Тав. **ЖИШИГ МАЯГТ**

#### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших  
1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт  
2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх  
3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх  
4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа  
5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа *6 сар* байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах  
6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр  
7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь  
8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах  
9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах  
10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх  
11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **100%** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup> 9.1. Алданги оногдуулах хувь: **0.5%**
- Алдангийн нийт дүн: **10%**

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

#### **НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

---

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.